

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2024 оны ... дугаар сарын ... -ны өдрийн
... дугаар албан бичгийн хавсралт



**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН
ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР
ХОТ**

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтыг дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг болох “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг баталсан.

Тус баримт бичгийн хүрээнд Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Амар тайван, аюулгүй нийгэм, Бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 арга хэмжээг тусгасан байна.

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

1.1.Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, баталсан шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

1.2 Арга зүй

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2-т заасан аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2023 онд батлагдаагүй, зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшинг он тус бүрээр тодорхойлоогүй тул Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 18.3.3 дахь заалтын дагуу хүрэх үр дүнг тооцох боломжгүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1-д заасан “хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшнийг тодорхойлсон байх” заалт хэрэгжээгүй, нарийвчилсан төлөвлөгөө байхгүй, тайлан ирүүлэхдээ 2023 оны хэрэгжилтээр зорилтот түвшинг тодорхойлсон, зорилт, арга хэмжээний биелэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалт буюу “Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшнийг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед

хэрэгжилтийн хувийг тодорхойлоход ... аргачлалаар тооцно” гэж заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ирүүлсэн тул “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2023 оны хэрэгжилтийн явцыг тайлагнасан болно.

Монгол Улсын Их Хурлын харьяа байгууллагаас тайлан ирүүлээгүй Шүүхийн ерөнхий зөвлөлийн хариуцан хэрэгжүүлэх 1 арга хэмжээ, Хүний эрхийн үндэсний комиссын 2, Төрийн албаны зөвлөлийн 2, Шадар сайдын ажлын албаны 1 арга хэмжээг тус тус хэрэгжилт хангалтгүй гэж үнэлсэн.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 47 зорилт, 243 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2023 оны дүнгээр 80.4 хувийн хэрэгжилттэй байна. Энэ дүнг 2022 оны хэрэгжилттэй харьцуулахад 6.2 хувиар нэмэгдсэн байна.

График 1. Зорилго тус бүрийн хэрэгжилт, хувиар



Бодлогын үндсэн 9 зорилгын хүрээнд хэрэгжилтийг авч үзвэл, “Амар тайван, аюулгүй нийгэм” зорилгын хэрэгжилт 91.7 хувь, “Амьдралын чанар ба дундаж давхарга” 90.0 хувь, “Эдийн засаг” 84.0 хувь байгаа нь бусад зорилгоос хэрэгжилт өндөр байна.

Хүснэгт 1. Зорилгын үнэлгээ, хэрэгжилтийн хувиар

Зорилго	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
		100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
Нэг. Үндэсний нэгдмэл үнэт зүйл	16	4	5	5	1	1	-	80.0
Хоёр. Хүний хөгжил	49	19	9	13	4	3	1	79.8
Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга	27	13	11	2	-	-	1	90.0
Дөрөв. Эдийн засаг	35	18	9	2	2	3	1	84.0
Тав. Засаглал	25	7	4	3	5	-	6	60.8
Зургаа. Ногоон хөгжил	18	2	5	7	2	1	1	70.6
Долоо. Амар тайван, аюулгүй нийгэм	23	16	4	1	1	1	-	91.7
Найм. Бүс, орон нутгийн хөгжил	29	14	5	6	1	2	1	82.1

Ес.Улаанбаатар ба дагуул хот	21	10	2	4	4	1	-	80.5
Нийт	243	103	54	43	20	12	11	80.4

Нийт арга хэмжээний 32.1 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 43.2 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 19.3 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 5.3 хувь нь үр дүнгүй гэж үнэлэгдсэн.

2.1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл

Үндэсний нэгдмэл үнэт зүйл буюу “Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ” гэсэн нэгдүгээр зорилгын хүрээнд Үндэсний бахархал, эв нэгдэл, Нүүдлийн соёл иргэншилт монгол, Монгол хэл бичиг, Эрдэм судлал, нийгмийн соёл гэгээрэл, Дэлхийн монгол гэсэн 5 чиглэлийг суурь болгон 5 зорилтыг дэвшүүлж, 16 арга хэмжээг баталсан.

Дээрх 5 зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх 16 арга хэмжээний хэрэгжилтийн явц дунджаар 80.0 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 2. Үндэсний нэгдмэл үнэт зүйл зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	Үндэсний бахархал, эв нэгдэл	5	1	2	1	-	1	-	76.0
2	Нүүдлийн соёл иргэншилт монгол	4	2	1	1	-	-	-	90.0
3	Монгол хэл, бичиг	2	-	-	2	-	-	-	70.0
4	Эрдэм судлал-нийгмийн соён гэгээрэл	2	1	-	1	-	-	-	85.0
5	Дэлхийн Монгол	3	-	2	-	1	-	-	76.7
Нийт		16	4	5	5	1	1	-	80.0

Зорилт тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, үндэсний бахархал, эв нэгдэл зорилтын 5 арга хэмжээ 76.0 хувь, нүүдлийн соёл иргэншилт монгол зорилтын 4 арга хэмжээ 90.0 хувь, монгол хэл, бичиг зорилтын 2 арга хэмжээ 70.0 хувь, эрдэм судлал-нийгмийн соён гэгээрэл зорилтын 2 арга хэмжээ 85.0 хувь, дэлхийн монгол зорилтын 3 арга хэмжээ 76.7 хувийн хэрэгжилттэй байна.

Энэ хүрээнд Соёлын яамнаас хэрэгжүүлсэн соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, нүүдлийн соёл, иргэншлийн судалгааны төв байгуулах ажлыг эхлүүлсэн байх зэрэг 4 арга хэмжээ “үр дүнтэй” хэрэгжсэн байна.

2.2. Хүний хөгжил

Хүний хөгжлийн асуудлыг “Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ” гэсэн хоёрдугаар зорилгын хүрээнд боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, шинжлэх ухаан, инновац, хүнд ээлтэй амьдрах орчин, хөдөлмөрийн зах зээл, монгол хүний удмын сан гэсэн чиглэлийг суурь болгон 7 зорилтыг дэвшүүлэн, 49 арга хэмжээг тодорхойлсон.

Дээрх 7 зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх 49 арга хэмжээний хэрэгжилтийн явц дунджаар 79.8 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 3. Хүний хөгжил зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	Боловсрол	12	9	1	1	1	-	-	92.5
2	Эрүүл мэнд	8	1	3	4	-	-	-	81.3
3	Гэр бүл	5	-	1	2	1	-	1	56.0
4	Шинжлэх ухаан, технологи, инноваци	9	6	2	1	-	-	-	94.4
5	Хүнд ээлтэй амьдрах орчин	6	-	1	3	1	1	-	63.3
6	Хөдөлмөрийн зах зээл	5	2	-	1	1	1	-	70.0
7	Монгол хүний удмын сан	4	1	1	1	-	1	-	72.5
Нийт		49	19	9	13	4	3	1	79.8

Зорилт тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, боловсрол зорилтын 12 арга хэмжээ 92.5 хувь, эрүүл мэндийн салбар зорилтын 8 арга хэмжээ 81.3 хувь, гэр бүл зорилтын 5 арга хэмжээ 56.0 хувь, шинжлэх ухаан, инновац зорилтын 9 арга хэмжээ 94.4 хувь, хүнд ээлтэй амьдрах орчин зорилтын 6 арга хэмжээ 63.3 хувь, хөдөлмөрийн зах зээл зорилтын 5 арга хэмжээ 70.0 хувь, Монгол хүний удмын сан зорилтын 4 арга хэмжээ 72.5 хувийн хэрэгжилттэй байна.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн 7 зорилтын 49 арга хэмжээнээс 5 зорилтын 19 арга хэмжээ нь “үр дүнтэй”, 7 зорилтын 22 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 5 зорилтын хэрэгжилт 7 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн бол гэр бүл зорилтын 1 арга хэмжээ “үр дүнгүй” буюу удирдлага зохион байгуулалт хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2.3. Амьдралын чанар ба дундаж давхарга

“Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн гуравдугаар зорилгын хүрээнд нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл, орлогод нийцсэн орон байр, хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес, дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, газрын харилцааны асуудлыг хамруулан 6 зорилт дэвшүүлсэн.

Дээрх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 27 арга хэмжээний хэрэгжилтийн явц дунджаар 90.0 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 4. Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл	5	3	2	-	-	-	-	96.0

2	Орлогод нийцсэн орон байр	4	1	2	1	-	-	-	87.5
3	Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес	5	3	1	1	-	-	-	92.0
4	Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт	2	1	1	-	-	-	-	95.0
5	Эрүүл, идэвхитэй амьдралын хэв маяг	5	1	4	-	-	-	-	92.0
6	Газрын харилцаа	6	4	1	-	-	-	1	81.7
Нийт		27	13	11	2	-	-	1	90.0

Зорилт тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл зорилтын 5 арга хэмжээ 96.0 хувь, орлогод нийцсэн орон байр зорилтын 4 арга хэмжээ 87.5 хувь, хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес зорилтын 5 арга хэмжээ 92.0 хувь, дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт зорилтын 2 арга хэмжээ 95.0 хувь, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг зорилтын 5 арга хэмжээ 92.0 хувь, газрын харилцаа зорилтын 6 арга хэмжээ 81.7 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн байна. Үүнээс 6 зорилтын хүрээнд 13 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь буюу үр дүнтэй, зорилтот түвшиндээ хүрч хэрэгжсэн бол газрын харилцаа зорилтын 1 арга хэмжээ хэрэгжилт хангалтгүй байна.

Зорилгын хүрээнд нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ, иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ зэрэг 13 ажил тодорхой үр дүнд хүрсэн байна.

2.4. Эдийн засаг

“Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно” гэсэн дөрөвдүгээр зорилгын хүрээнд Чинээлэг монгол, Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд, Ухаалаг санхүүгийн зээл, Бүс нутгийн хамтын ажиллагаа, Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн, Үндэсний баялгийн сан гэсэн чиглэлийг суурь болгон 6 зорилтыг тодорхойлсон. Эдгээр 35 арга хэмжээний хэрэгжилтийн явц дунджаар 84.0 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 5. Эдийн засаг зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	Чинээлэг монгол	7	7	-	-	-	-	-	100.0
2	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд	16	3	6	2	2	3	-	73.1
3	Ухаалаг санхүүгийн зах зээл	5	4	-	-	-	-	1	80.0
4	Бүс нутгийн хамтын ажиллагаа	4	3	1	-	-	-	-	97.5
5	Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн	2	-	2	-	-	-	-	90.0

6	Үндэсний баялгийн сан	1	1	-	-	-	-	-	100.0
Нийт		35	18	9	2	2	3	1	84.0

Зорилт тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, чинээлэг монгол зорилтын хүрээнд 7 арга хэмжээ 100.0 хувь, эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд зорилтын 16 арга хэмжээ 73.1 хувь, ухаалаг санхүүгийн зах зээл зорилтын хүрээнд 5 арга хэмжээ 80.0 хувь, Бүс нутгийн хамтын ажиллагаа зорилтын 4 арга хэмжээ 97.5 хувь, өрсөлдөх чадвартай брэнд бүтэгдэхүүн зорилтын 2 арга хэмжээ 90.0 хувь, Үндэсний баялгийн сан зорилтын 1 арга хэмжээ 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Тус зорилгын эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн арга хэмжээний хүрээнд “цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангана”, “улс, орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүй төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ”, “Арцсуурь боомтыг Нөмрөг сумтай, Улиастай хотыг Алтай хоттой холбосон авто замуудыг барина” зэрэг 3 арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

2.5. Засаглал

“Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” зорилгын дор ухаалаг засаглал, ухаалаг бүтэц, цахим монгол, чадварлаг, ёс зүйтэй төрийн алба, хүний эрхийг дээдэлсэн нийгэм, авлигагүй засаглал гэсэн чиглэлийг суурь болгон 6 зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээг баталсан. Эдгээр арга хэмжээний хэрэгжилтийн явц дунджаар 60.8 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Хүснэгт 6. Засаглал зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	Ухаалаг засаглал	4	-	2	-	2	-	-	70.0
2	Ухаалаг бүтэц	3	1	-	1	1	-	-	73.3
3	Цахим монгол	4	3	1	-	-	-	-	97.5
4	Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба	7	-	-	2	2	-	3	34.3
5	Хүний эрхийг дээдэлсэн нийгэм	4	-	1	-	-	-	3	22.5
6	Авлигагүй засаглал	3	3	-	-	-	-	-	100.0
Нийт		25	7	4	3	5	-	6	60.8

Зорилт тус бүрээр хэрэгжилтийн явцыг авч үзэхэд, Ухаалаг засаглал зорилтын 4 арга хэмжээ 70.0 хувь, Ухаалаг бүтэц зорилтын 3 арга хэмжээ 73.3 хувь, Цахим монгол зорилтын 4 арга хэмжээ 97.5 хувь, Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба зорилтын 7 арга хэмжээ 34.3 хувь, Хүний эрхийг дээдэлсэн нийгэм зорилтын 4 арга хэмжээ 22.5 хувь, Авлигагүй засаглал зорилтын 3 арга хэмжээ 100.0 хувийн хэрэгжилттэй байна. Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба зорилтын хүрээнд 3, Хүний

эрхийг дээдэлсэн нийгэм зорилтын хүрээнд 3 арга хэмжээний хэрэгжилтийг тус тус тайлагнаагүйгээс шалтгаалан тухайн зорилтын хэрэгжилт бага үнэлэгдсэн байна.

2.6. Ногоон хөгжил

“Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана” гэсэн 6 дугаар зорилгын хүрээнд Эх байгаль анхдагч экосистем, Байгалийн баялгийн үр өгөөж, Үнэт баялаг ус, Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил гэсэн чиглэлийг суурь болгон 4 зорилтыг тодорхойлж, авч хэрэгжүүлэх 18 арга хэмжээг баталсан. Эдгээр арга хэмжээний хэрэгжилтийн явц дунджаар 70.6 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 7. Ногоон хөгжил зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

ДД	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	Эх байгаль анхдагч экосистем	2	-	1	-	-	1	-	60.0
2	Байгалийн баялгийн үр өгөөж	5	1	3	1	-	-	-	88.0
3	Үнэт баялаг ус	4	-	-	3	1	-	-	65.0
4	Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил	7	1	1	3	1	-	1	64.3
Нийт		18	2	5	7	2	1	1	70.6

Зорилт тус бүрээр хэрэгжилтийн явцыг авч үзэхэд, эх байгаль анхдагч экосистем ухаалаг зорилтын 2 арга хэмжээ 60.0 хувь, байгалийн баялгийн үр өгөөж зорилтын 5 арга хэмжээ 88.0 хувь, үнэт баялаг ус зорилтын 4 арга хэмжээ 65.0 хувь, нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил зорилтын 7 арга хэмжээ 64.3 хувийн хэрэгжилттэй байна.

Эх байгаль анхдагч экосистем зорилтын хүрээн дэх “Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөн нийт газар нутгийн 27 хувьд хүргэж, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна”, “Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил зорилтын аймгийн төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдэж, хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна” зэрэг зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2.7. Амар тайван, аюулгүй нийгэм

“Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана” гэсэн зорилгын хүрээнд Зэвсэгт хүчин, Дархан хил, Хүн, нийгмийн амар тайван байдал, Хууль сахиулах салбарын хөгжил, Мэдээллийн аюулгүй байдал гэсэн чиглэлийг суурь болгон 5 зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд 23 арга хэмжээг төлөвлөсөн. Эдгээр арга хэмжээний хэрэгжилтийн явц дунджаар 91.7 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 8. Амар тайван, аюулгүй нийгэм зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	Зэвсэгт хүчин	4	-	3	1	-	-	-	85.0
2	Дархан хил	4	3	-	-	1	-	-	87.5
3	Хүн, нийгмийн амар тайван байдал	6	5	-	-	-	1	-	88.3
4	Хууль сахиулах салбарын хөгжил	7	7	-	-	-	-	-	100.0
5	Мэдээллийн аюулгүй байдал	2	1	1	-	-	-	-	95.0
Нийт		23	16	4	1	1	1	-	91.7

Зорилт тус бүрээр хэрэгжилтийн явцыг авч үзэхэд, зэвсэгт хүчин зорилтын 4 арга хэмжээний хэрэгжилт 85.0 хувь, дархан хил зорилтын 4 арга хэмжээ 87.5 хувь, хүн, нийгмийн амар тайван байдал зорилтын 6 арга хэмжээ 88.3 хувь, хууль сахиулах салбарын хөгжил зорилтын 7 арга хэмжээ 100.0 хувь, мэдээллийн аюулгүй байдал зорилтын 2 арга хэмжээ 95.0 хувийн хэрэгжилттэй байна.

Тус зорилгын хүрээнд 16 арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн бол 7 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн байна. Харин үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулах зэрэг арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2.8. Бүс, орон нутгийн хөгжил

“Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ” гэсэн наймдугаар зорилгын хүрээнд Дэд бүтэц, Аялал жуулчлал, Тогтвортой хөдөө аж ахуй гэсэн чиглэлийг суурь болгож, 3 үндсэн зорилт дэвшүүлж, хэрэгжүүлэх 29 арга хэмжээг тодорхойлсон. Эдгээр 29 арга хэмжээний хэрэгжилтийн явц дунджаар 82.1 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 9. Бүс, орон нутгийн хөгжил зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	Дэд бүтэц	11	4	4	1	-	1	1	78.2
2	Аялал жуулчлал	3	-	-	2	1	-	-	63.3
3	Тогтвортой хөдөө аж ахуй	15	10	1	3	-	1	-	88.7
Нийт		29	14	5	6	1	2	1	82.1

Зорилт тус бүрээр хэрэгжилтийн явцыг авч үзэхэд, дэд бүтэц зорилтын 11 арга хэмжээний хэрэгжилт 78.2 хувь, аялал жуулчлал зорилтын 3 арга хэмжээ 63.3 хувь, тогтвортой хөдөө аж ахуй зорилтын 15 арга хэмжээ 88.7 хувийн хэрэгжилттэй байна.

Орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг аймгууд, аюулын эрсдэл өндөртэй зарим сумдад үе шаттайгаар байгуулах, Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх, Малын гаралтай түүхий эд боловсруулах, экспортлох үйлдвэр, технологийн парк байгуулж, ажлын байрыг шинээр бий болгож, малчдын орлогыг өсгөх зэрэг 3 арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.9. Улаанбаатар ба дагуул хот

“Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ” гэсэн 9 дэх зорилгын хүрээнд Хүн төвтэй хот, Орчин төвтэй шийдэл, Төлөвлөлт төвтэй хөгжил, Хотын сайн засаглал, Дагуул хот гэсэн чиглэлийг суурь болгож 5 зорилт дэвшүүлж, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 21 арга хэмжээг тодорхойлсон. Эдгээр арга хэмжээний хэрэгжилтийн явц дунджаар 80.5 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 10. Улаанбаатар ба дагуул хот зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	Хүн төвтэй хот	3	2	-	1	-	-	-	90.0
2	Орчин төвтэй шийдэл	4	2	1	-	1	-	-	85.0
3	Төлөвлөлт төвтэй хөгжил	5	2	1	2	-	-	-	86.0
4	Хотын сайн засаглал	3	3	-	-	-	-	-	100.0
5	Дагуул хот	6	1	-	1	3	1	-	58.3
Нийт		21	10	2	4	4	1	-	80.5

Зорилт тус бүрээр хэрэгжилтийн явцыг авч үзэхэд, хүн төвтэй хот зорилтын 3 арга хэмжээ 90.0 хувь, орчин төвтэй шийдэл зорилтын 4 арга хэмжээ 85.0 хувь, төлөвлөлт төвтэй хөгжил зорилтын 5 арга хэмжээ 86.0 хувь, хотын сайн засаглал зорилтын 3 арга хэмжээ 100.0 хувь, дагуул хот зорилтын 6 арга хэмжээ 58.3 хувийн хэрэгжилттэй байна.

Тус зорилгын хүрээнд 10 арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй буюу 100.0 хувийн хэрэгжилттэй, 6 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай үнэлэгдсэн бол Хот, тосгоныг холбосон хурдны тойрог зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, монгол брэндийн худалдааны төвийг нээн ажиллуулах зэрэг 5 арга хэмжээний хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

Гурав. Шалгуур үзүүлэлт

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 95 шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг 2025 оноор тодорхойлж баталсан.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу журмын 3в хавсралтаар нэгтгэн гаргасан.

Нийт 94¹ шалгуур үзүүлэлтээс 13 шалгуур үзүүлэлтийг тайлагнах хугацаа болоогүй, 3 шалгуур үзүүлэлтийг үнэлэх боломжгүй буюу тооцох аргачлал тодорхойгүй байна. Шалгуур үзүүлэлтийн 2023 оны хүрсэн түвшний мэдээллийг үндсэн хэрэгжүүлэх 25 байгууллага ирүүлэхээс 14 байгууллага 78 шалгуур үзүүлэлтийн мэдээллийг ирүүлсэн. Нийт 62 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд, дунджаар 52.8 хувь байна.

Шалгуур үзүүлэлтэд тусгагдсан номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь, 1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо, төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин, дээд боловсролын нийт багшид докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь зэрэг нийт 21 шалгуур үзүүлэлт 2023 оны зорилтот түвшиндээ хүрсэн буюу 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Харин 2023 оны хүрсэн түвшин нь суурь түвшнээс буурсан, тухайн оны зорилтот түвшинд хүрээгүй зэрэг үндэслэлээр 20 шалгуур үзүүлэлт 0.0 хувиар үнэлэгдсэн. Тухайлбал, 1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тооны шалгуур үзүүлэлт тайлант хугацаанд зорилтот түвшнээс 0.6 хувь, төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тооны шалгуур үзүүлэлт тайлант хугацаанд зорилтот түвшнээс 1.4 хувиар тус тус нэмэгдсэн бол соёл урлагийн үйлчилгээний хүртээмж 31.2 хувь болж суурь түвшнээс буурсан үзүүлэлттэй байна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жингийн үзүүлэлт 2-5 нас, 3-5 насны бүлгээр 89.7 хувь, 92.8 хувиар үнэлэгдсэн буюу 2023 оны хүрэх түвшинг бүрэн хангасан байна.

Тэтгэвэр, тэтгэмжийн өсөлтийг инфляцын түвшинтэй уялдуулж 6.0 хувиар нэмэгдүүлэхээр тооцсоноос 2020-2023 онд 65.1 хувиар өссөн, 2023 онд 10.0 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бол эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан хувь 93.3 хувь байна.

Төв банкны тухай хуульд Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах гэж тодорхойлсны дагуу Монголбанкаас инфляцыг дунд хугацаанд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахаар зорьсон. Жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд инфляц 7.9 хувь байсан нь зорилтот түвшинг хангасан.

Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь 21.1 хувь, Хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь 48.0 хувь, Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь 99.3 хувь болж тус тус нэмэгдсэн буюу 2023 оны хүрэх түвшинг бүрэн хангасан байна.

¹ “Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-ий 15 болон 18 дахь “Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшнээр)” шалгуур үзүүлэлтүүд техникийн алдааны улмаас давхцсан тул хасч тооцов.

Ажил эрхэлж байгаа төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувь (МСҮТ, их, дээд сургууль) болон хотын хөгжлийн индекс суурь түвшнээс буурсан үзүүлэлттэй байна.

Уул уурхайн салбар 2023 оны 3 дугаар улирлын байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 27.0 хувь, 2023 оны эхний 11 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 71.0 хувь, экспортын 92.0 хувь, 2023 оны эхний 10 сарын байдлаар төсвийн орлогын 34.0 хувийг тус тус бүрдүүлж байна. Уул уурхайн салбарын орлого зэсийн баяжмал, нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг голлох ашигт малтмалаас төвлөрч байх бөгөөд 2023 оны хүрэх түвшнээс 0.4 хувиар бага байна.

Улаанбаатар хотын агаар дахь РМ 2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж 2023 оны хүрэх түвшин болох 49.6-аас 41 мкг/м³, РМ10 тоосонцрын жилийн дундаж агууламж 109.2-оос 82 мкг/м³ болж буурсан байна. Шалгуур үзүүлэлтийг хангах хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор 2023 онд агаарын чанарыг сайжруулах бүсэд хяналт шалгалт, 5,012 айл өрхийг 4 кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах, техникийн боломж бүрдүүлэх 12 багц ажил, Хас, Хаан банкны ногоон зээлийг шийдвэрлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

Дөрөв. Бодлогын арга хэмжээний санхүүжилт

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 67 арга хэмжээнд хамаарах зарим үйл ажиллагаанд нийт 11468.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Үүнд: “Эдийн засаг” зорилгын санхүүжилтэд 8,623.9 тэрбум төгрөг, “Хүний хөгжил” зорилгын санхүүжилтэд 1,661.8 тэрбум төгрөгийг зарцуулсан нь бусад зорилгын санхүүжилтээс илүү дүнтэй байна. Түүнчлэн “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” зорилгыг хэрэгжүүлэхэд 762.0 сая төгрөг, “Амьдралын чанар ба дундаж давхарга” зорилгод 478.9 тэрбум төгрөг, “Засаглал” зорилгод 682.0 сая төгрөг, “Ногоон хөгжил” зорилгод 249.8 тэрбум төгрөг, “Амар тайван, аюулгүй нийгэм” зорилгод 275.8 тэрбум төгрөг, “Бүс, орон нутгийн хөгжил” зорилгод 16.5 тэрбум төгрөг, “Улаанбаатар ба дагуул хот” зорилгыг хэрэгжүүлэхэд 160.3 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн байна.

Хүснэгт 11. Санхүүжилтийн гүйцэтгэл (зорилгоор)

№	Зорилго	Арга хэмжээний тоо	Санхүүжсэн арга хэмжээ	Санхүүжилтийн дүн /тэрбум төгрөг/	Үүнээс:				
					Улсын төсөв	Гадаадын зээл, тусламж	Концесс, ТХХТ	Тусгай сан	Бусад
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	16	5	0.76	0.72	-	-	0.05	-
2	Хүний хөгжил	49	9	1,661.77	12.52	-	-	1,649.25	-
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	27	7	478.92	32.70	386.52	-	59.70	-
4	Эдийн засаг	35	15	8,623.93	2,708.34	1,022.06	4,878.73	14.80	-
5	Засаглал	25	1	0.68	0.68	-	-	-	-
6	Ногоон хөгжил	18	12	249.81	207.25	8.08	-	-	34.48
7	Амар тайван, аюулгүй нийгэм	23	11	275.77	24.03	216.12	-	31.71	3.90

8	Бүс, орон нутгийн хөгжил	29	3	16.46	14.63	1.83	-	-	-
9	Улаанбаатар ба дагуул хот	21	4	160.27	130.06	-	-	-	30.21
Нийт		243	67	11,468.37	3,130.93	1,634.61	4,878.73	1,755.51	68.59

(Гадаад валютын ханшийг Монголбанкны 2023.12.31-ний өдрийн төгрөгийн ханшаар тооцоолов.)

Зарцуулсан хөрөнгийн хэмжээг эх үүсвэрээр авч үзвэл, улсын төсвөөс 3,130.9 тэрбум төгрөгөөр 39 арга хэмжээ, гадаадын зээл, тусламжаас 1,634.6 тэрбум төгрөгөөр 12 арга хэмжээ, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4,878.7 тэрбум төгрөгөөр 3 арга хэмжээ, Засгийн газрын тусгай сангаас 1,755.5 тэрбум төгрөгөөр 7 арга хэмжээ, бусад эх үүсвэрээр 68.6 тэрбум төгрөгөөр 6 арга хэмжээ тус тус санхүүжсэн байна.

Хүснэгт 12. Санхүүжилтийн эх үүсвэр

Санхүүжилтийн эх үүсвэр	Гүйцэтгэл /сая.төг/	Санхүүжсэн арга хэмжээний тоо (давхардсан тоогоор)
Улсын төсөв	3,130,927.0	39
Гадаадын зээл тусламж	1,634,613.6	12
Концесс, ТХХТ	4,878,731.0	3
Орон нутгийн төсөв	31,201.7	1
Тусгай сан	1,755,506.5	7
Бусад эх үүсвэр	37,387.4	5
Нийт	11,468,367.2	67

Хүснэгт 13. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт (байгууллагаар)

дд	Байгууллага	Төсөл, арга хэмжээ	Үнэлгээ						Дундаж хувь
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0.0	
1	ЗГХЭГ	9	-	-	2	5	1	1	46.6
2	ШСАА	4	2	-	1	-	1	-	75.0
3	ЭЗХЯ	6	4	2	-	-	-	-	95.0
4	ЦХХХЯ	27	1	7	11	4	2	2	96.7
5	БОАЖЯ	4	2	2	-	-	-	-	65.2
6	ГХЯ	17	14	2	-	-	-	1	95.0
7	СаЯ	22	20	2	-	-	-	-	92.9
8	ХЗДХЯ	23	15	5	2	-	1	-	95.0
9	ХХААХҮЯ	4	-	3	1	-	-	-	88.3
10	БХЯ	22	10	2	4	3	2	1	85.0
11	БХБЯ	23	16	6	1	-	-	-	75.9
12	БШУЯ	14	5	5	3	-	1	-	92.6
13	ЗТХЯ	1	-	-	1	-	-	-	85.0
14	УУХҮЯ	17	8	5	2	-	1	1	70.0
15	ХНХЯ	5	-	-	1	2	2	-	77.1
16	ЭХЯ	11	1	3	6	-	1	-	54.0
17	ЭМЯ	14	6	6	2	-	-	-	74.5
18	СоЯ	6	4	2	-	-	-	-	87.9
19	ТЕГ	0	-	-	-	-	-	-	100.0
20	БТСУХ	4	-	4	-	-	-	-	90.0
21	НЗДТГ	7	4	1	1	1	-	-	87.1

ХЭҮК, ШЕЗ, ТАЗ тайлан ирүүлээгүй бөгөөд үнэлгээг 0.0 хувь буюу үр дүнгүй гэсэн үнэлгээнд оруулж тооцсон бөгөөд ХЭҮК, ШЕЗ, ТАЗ-ийн эрхлэх асуудалд хамаарах арга хэмжээ www.unelgee.gov.mn мэдээллийн цахим санд хуваарилагдаагүй байна.

Тав. Дүгнэлт

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 80.4 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн ба үнэлгээг нийтлэг журмын 6.2.3-д заасан ангилалд шилжүүлэн тооцвол, 104 арга хэмжээ “үр дүнтэй”, 96 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 32 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 11 арга хэмжээ “үр дүнгүй” үнэлэгдлээ.

Хүснэгт 14. Зорилт арга хэмжээний дундаж үнэлгээ

Ангилал	Үнэлгээ, %	Арга хэмжээний тоо	Нийт дүнд эзлэх хувь
Үр дүнтэй	100.0	103	42.4
Тодорхой үр дүнд хүрсэн	70-99.0	97	39.9
Эрчимжүүлэх шаардлагатай	30-69.0	32	13.2
Үр дүнгүй	0-29.0	11	4.5
Нийт дүн	80.4	243	100.0

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны хэрэгжилтийн явцын тайланг нийт 23 байгууллага ирүүлснээс 14 яам, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний Биеийн тамир, спортын улсын хороо, Шадар сайдын харьяа Стандарт, хэмжил зүйн газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар тайлангаа хугацаандаа ирүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Тагнуулын ерөнхий газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Шадар сайдын харьяа Онцгой байдлын ерөнхий газар хугацаа хоцроож тайлагнасан.

Яамд, агентлагууд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн 2023 оны хэрэгжилтийг тайлагнахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах баримт бичгийн зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хэмжих нэгж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тайлагнахгүй байх асуудал түгээмэл ажиглагдаж байна.

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (www.unelgee.gov.mn)-д хэрэгжилтийн тайланг оруулахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхой тусгах, нотлох баримтыг хавсаргах, гол үр дүнг тодорхой тусгах, 2000 тэмдэгтэд багтаан иж бүрэн тайлагнах шаардлагатай байна.

Зургаа. Цаашид авах арга хэмжээний санал

Бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайлагналыг сайжруулах хүрээнд:

1.Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn мэдээллийн цахим санд хэрэгжилтийн тайланг оруулахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхой тусгаж, нотлох баримтыг хавсарган, иж бүрэн тайлагнах, тайланд санхүүжилтийн гүйцэтгэлийг оруулахдаа мөнгөн дүнг сайтар нягталж, зарцуулалтыг бүрэн гүйцэд тайлагнаж байх;

2.Тайлангийн үг, үсэг, утга найруулгын алдаанаас гадна санхүүжилтийн гүйцэтгэлийн тооцооллыг сайтар нягталж, хянах (“сая төгрөг” гэж тооцсон

тохиолдолд санхүүжилтийн дүнг саяар илэрхийлж, нэгжийг алдаагүй оруулах, цифр, оронгийн алдаа гаргахгүй байх);

3.Төлөвлөгөөнд үндсэн хэрэгжүүлэгчээр батлагдсан бол хамтран хэрэгжүүлэгч байгууллага тус бүрээс хэрэгжилтийн тайлан болон санхүүжилтийн гүйцэтгэлийг авч нэгтгэх, мэргэжлийн болон гадаад товчилсон үг хэллэгийг тайлбартайгаар ирүүлэхэд анхаарах;

4.Шалгуур үзүүлэлтийг тухайн хариуцагч байгууллагаас харгалзах он бүрийн хүрэх түвшинг судалгаа, шинжилгээнд үндэслэн тодорхойлох, тухайн оны хүрэх түвшинд хүрээгүй бол холбогдох тайлбар мэдээллийг ирүүлэх;

5.Төслийн явц, үйл ажиллагаатай холбоотой хяналт-шалгалт, мониторинг хийсэн бол хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд мониторингийн тайланг хавсаргаж ирүүлэх.

----- оОо -----